



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2018/4



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 04 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 04 сард 464 эх амаржиж, 464 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 57(14.0%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 54(13.2%)-өөр, 128 хүн нас барсан нь 13(11.3%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 336 болж өмнөх оны мөн үеэс 41(13.9%)-ээр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 6.9, нас баралт 1.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус өссөн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 04 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1-ээр илүү байна.



1.2 Эрүүл мэнд


2018 оны 04 сарын байдлаар 119.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар, 3.7 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар тус тус буурч, 6.1 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өслөө.

2018 оны 04 сард 539 эх жирэмсний хяналтанд орсны 86.8 хувь буюу 468 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Түргэн тусламжийн дуудлага 7.0 мянган удаа гарсны 1.2 мянга буюу 17.1 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 6.1 хувиар өсч, алсын дуудлага адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 992 хүн бэртэж, 24 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 126 (14.5%)-оор нэмэгдэж, нас барсан хүний тоо 3 (11.1%) хувиар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 04 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 28.9 хувь, хавдар 22.7 хувь, хоол шингээх эрхтний өвчин 8.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 8.6 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 18.8 хувь, бусад төрлийн өвчин 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 215 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 181(45.7%)-ээр буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 2.9 хувь, трихоминиаз 34.7 хувь, тэмбүү 5.1 хувь, вирус гепатит 83.3 хувиар, бусад төрлийн өвчин 82.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 04 сарын эцэст 741 болсны 714 (96.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 27 (3.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 992 (57.2 %) хүнээр буурч, өмнөх сараас 45(6.5%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 355 (47.9%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 413 (55.7%) нь Сайншанд суманд, 124 (16.7%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 59.4 хувь нь бүрэн дунд, 22.0 хувь нь дээд, 6.7 хувь нь техник болон мэргэжлийн, 4.2 хувь нь бүрэн бус дунд, 4.7 хувь нь тусгай дунд, 0.5 хувь нь бага, 2.3 хувь нь боловсролгүй, 0.1 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 04-р сард



Оны гарсаар 767 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 43 иргэн ажилд зуучлагдан орж, 310 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 59 ажлын байрны 17(28.8%) нь үйлчилгээний, 13(22.0%) нь уул уурхайн олборлолтын салбарын захиалга байна. Ажил хайгч 43 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 26 (60.5%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар



1.4 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 04 сард 10504.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1881.3 (21.8%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 04 сард өмнөх оны мөн үеэс 1881.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1350.2(25.7%)


сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 224.0(25.9%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 148.5(24.8%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 04 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 14282.2 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 1928.5 (15.6%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 10432.6(73.0%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2176.1(15.2%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 782.0(5.5%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 651.6(4.6%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 239.9(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 04 сард нийгмийн халамжийн сангаас 19458 иргэнд 2828.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 4226 (27.7%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 798.2 (39.3%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.




Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 5585(28.7%) иргэнд 758.2(26.8%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1274 хүн хамрагдсан нь өмнөх оноос 120 (10.4%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 426.3 (2.3² дахин) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 990 иргэнд 248.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 863 иргэнд 188.5 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 5971 иргэнд хамруулж 233.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 10360 иргэнд 1423.1 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/






Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 04 сарын байдлаар 203 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 40 хүн гэмтэж, 8 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 20(8.9%)-оор, нас барсан хүний тоо 3(27.2%)-аар, гэмтсэн хүний тоо 38(48.7%) -аар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний амины гэмт хэрэг 9 (60.0%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 20 (32.8%)-оор, мал хулгайлах гэмт хэрэг 2(8.7%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг 8 (34.8%)-аар, бусад гэмт хэрэг 28 (77.8%)-аар буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 97(47.8%) хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 41(20.2%) хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 15 (7.4%) хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг, 14(6.9%) хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 21 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54(74.0%) -оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Иххэт, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурч, Мандах, суманд өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 318.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 777.4 (70.9) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 230.5 (72.2%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 52 (25.6%) нь гэр сууцандаа, 26(12.8%) нь гудамж олон нийтийн газарт, 21(10.3%) нь согтуугаар, 19 (9.4%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 12(5.9%) бүлэглэн, 72(35.5%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 407 хүн эрүүлжүүлэгдэж, 89 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 04 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 458.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 101.5(28.4%) тэрбум төгрөгөөр, цэвэр зарлага 481.2 тэрбум төгрөг болж 136.4(39.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017-2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 87.1 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1276.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1277.3 мянган төгрөгийн

хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 1.1 (1.6%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 20.3 (30.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 04 дүгээр сарын эцэст 2465.2 сая төгрөг болж, өмнөх сараас 2224.1(47.4%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 663.3 (21.2%) сая төгрөгөөр тус тус буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.1 хувийг эзэлж, өмнөх сараас 1.0 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 04 дүгээр сарын эцэст 8471.4 сая төгрөг болж өмнөх сараас 1366.0 (19.2%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 143.3 (1.7%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.04 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.04 сард



2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 04 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсөвт 9064.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 116.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 56.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 68.7 хувийг татварын, 31.3 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 04-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 1493.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 243.6 (19.5%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 553.9 (59.0%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 04 дугаар сард өмнөх сараас 0.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 2.2 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг 0.3 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0,5 хувь, орон сууц, ус цахилгаан, түлшний бүлэг 0,3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 04 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 04 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 04 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 51.4 хувь буюу 434.5 мянган толгой мал төллөж, төл бойжилт 98.4 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 64.7 (17.5%) мянган толгойгоор, төл бойжилт 59.9 (16.2%) мянган толгойгоор илүү юм.

Эхний 04-н сарын байдлаар 5915 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 5.0 (6.6 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 1.7 мянган толгой мал, Иххэт суманд 1.6 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 04-р сард ноолуурын дундаж үнэ 84.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 29.0 (52.7%) мянган төгрөг өссөн байна. Харин тэмээний шир 20.0 мянган төгрөг, адууны шир 10.0 мянган төгрөг, хонины арьс 1.5 мянган төгрөг, үхрийн шир 20.0 мянган төгрөг-ийн ханштай байна. Сумдад эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 75.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 04 сард аж үйлдвэрийн салбарт 50146.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 72174.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2.2 дахин, борлуулалт 46.7 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 6.4 хувийг төрийн, 93.6 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 6.4 хувь, компани 93.2 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал дулаан 4.2 мян.ккал-аар, ус түгээлт 53.1 мян.м3-ээр, сувагжуулалт 17.3 мян.м3-ээр, нарийн боов 7.6 тонноор, бялуу 0.2 тонноор, сүүн бүтээгдэхүүн 0.5 мян.литрээр, вакуум цонх 624.2 м2-аар, нүүрс 159.2 мян.тонноор, цемент 78.4 мян.тонноор, модон эдлэл 11773,1 мян.төгрөгөөр, дээл 83 ширхэгээр, жижиг оёдол 4873.6 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 04 дүгээр сарын дундаж агаарын температур нутгийн өмнөд 10.1-10.9 хэм дулаан, Мандах, Дэлгэрэх, Иххэт сумдад 7.3-7.7 хэм дулаан, бусад нутгаар 8.4-9.2 хэм дулаан, агаарын хамгийн их температур сарын сүүлээр өдөртөө нийт сумдын нутгаар 29-31 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 8-16 хэм хүйтэн, сарын сүүлээр өдөртөө нийт нутгаар 47-54 хэм дулаан байв.

04 дүгээр сард нийт сумдын нутгаар 2-7 өдөр хур тунадастай байж, 4.1-18.0 мм хур тунадас орлоо.

Энэ сард нийт нутгаар салхины хамгийн их хурд Сайншанд суманд 26 м/с, Замын-Үүд, Хөвсгөл сумдад 23-24 м/с, Мандах, Эрдэнэ сумдад 21-22 м/с, бусад сумдын нутгаар 17-20 м/с хүрсэн. 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд, Замын-Үүд, Дэлгэрэх сумдад 24-25, Улаанбадрах суманд 7, бусад сумдын нутгаар 13-22 өдөр байлаа.



АГУУЛГА

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Дөрөв. Гэмт хэрэг

- 4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

Тав. Мөнгө, зээл

- 5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 5.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст

Зургаа. Орон нутгийн төсөв

- 6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 6.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

Долоо. Үнэ

- 7.1 Хэрэглээний үнийн индекс
- 7.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

Найм. Хөдөө аж ахуй

- 8.1 Мал төллөлт, төл бойжилт
- 8.2 Том малын зүй бус хорогдол
- 8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 8.4 Малын үнийн судалгаа, сумаар

Ес. Аж үйлдвэр

- 9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

Арав. Байгаль орчин

- 10.1 Цаг уурын үзүүлэлт

Тэмдэглэлийн тайлбар :

- (,,) - тухайн тоо, баримт байхгүй
- (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- (х) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2018 - 2017 | 2018 |
|--|-------------|--------|--------|---------|----------|-------------|------------------|
| | | | | | | | |
| 1. Бэлэн хүн ам | мянган хүн | 63.1 | 66.6 | 68.2 | 68.5 | 0.3 | 100.4 |
| - Төрсөн хүүхдийн тоо* | тоо | 500 | 492 | 410 | 464 | 54 | 113.2 |
| - Нас барсан хүний тоо - бодит тоогоор** | тоо | 100 | 106 | 115 | 128 | 13 | 111.3 |
| - Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор | тоо | 400 | 386 | 295 | 336 | 41 | 113.9 |
| - Нялхасын эндэгдэл - бодит тоогоор | тоо | 8 | 2 | 4 | 5 | 1 | 125.0 |
| - 1000 хүүхдэд ноогдох | тоо | 8.4 | 4.1 | 9.8 | 10.8 | 1.0 | 110.5 |
| 2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор | тоо | 318 | 1146 | 396 | 215 | -181 | 54.3 |
| - 10000 хүнд ногдох | тоо | 17.9 | 54 | 58 | 32 | -27 | 54.3 |
| 3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд | тоо | 1 326 | 1 129 | 1 733 | 741 | - 992 | 42.8 |
| - Үүнээс эмэгтэй | тоо | 758 | 602 | 902 | 355 | - 547 | 39.4 |
| - Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо | тоо | 33 | 27 | 40 | 17 | - 23 | 42.8 |
| 4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд | тоо | 76 | 114 | 77 | 19 | -58 | 24.7 |
| Үүнээс: Байнгын ажлын байр | тоо | 76 | 105 | 77 | 17 | -60 | 22.1 |
| Улирлын чанартай ажлын байр | тоо | 0 | 9 | 0 | 2 | 2 | |
| 5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор | тоо | 60 | 49 | 76 | 100 | 24 | 131.6 |
| - 10000 хүнд ногдох *** | тоо | 14 | 12 | 18 | 23 | 5 | 130.8 |
| 6.Бойжиж буй төл, мян толгой | толгой | 365901 | 360171 | 369727 | 429656.0 | 59929 | 116 |
| - Унага | толгой | 3750 | 4098 | 3373 | 5555.0 | 2182 | 165 |
| - Тугал | толгой | 5154 | 4197 | 3300 | 6085.0 | 2785 | 184 |
| - Ботго | толгой | 6918 | 5304 | 4484 | 4748.0 | 264 | 106 |
| - Хурга | толгой | 188826 | 183305 | 196592 | 225814.0 | 29222 | 115 |
| - Ишиг | толгой | 161253 | 163267 | 161978 | 187454.0 | 25476 | 116 |
| 7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн | сая төгрөг | 5008.8 | 6773.8 | 22881.6 | 50146.5 | 27264.9 | 2.2 ² |
| - Борлуулсан бүтээгдэхүүн | сая төгрөг | 4456.1 | 4422.5 | 49191.0 | 72174.5 | 22983.5 | 146.7 |

* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 04 сарын эцэст

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2017 I-IV | 2018 I-IV | Өсөлт | |
|---------------------------------------|-------------|-----------|-----------|-------|-------|
| | | Тоо | | | Хувь |
| 1. Амбулаторийн үзлэг | мян.хүн | 121.9 | 119.5 | -2.4 | 98.0 |
| 2. Ор хоног | мян.хүн | 41.1 | 44.0 | 2.9 | 107.1 |
| 3. Урьдчилан сэргийлэх тарилга | мян.хүн | 4.0 | 3.7 | -0.3 | 92.5 |
| 4. Эмчлүүлсэн хүний тоо | мян.хүн | 5.7 | 6.1 | 0.4 | 107.0 |
| 5. Түргэн тусламжын дуудлага | мян.хүн | 6.6 | 7.0 | 0.4 | 106.1 |
| Үүнээс: алсын дуудлага | мян.хүн | 1.2 | 1.2 | 0 | 100.0 |
| 6. Осол гэмтлийн өвчлөл | хүн | 866 | 992 | 126 | 114.5 |
| Үүнээс: нас баралт | хүн | 27 | 24 | -3 | 88.9 |
| 7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх | хүн | 541 | 539 | -2 | 99.6 |
| Үүнээс: эхний 3 сартайн хяналт | хүн | 470 | 468 | -2 | 99.6 |
| 8. Амаржсан эх | хүн | 407 | 464 | 57 | 114.0 |
| Үүнээс: нас баралт | хүн | 0 | 0 | 0 | 0.0 |
| 9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд | хүн | 0 | 1 | 1 | 0.0 |
| 10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | хүн | 4 | 5 | 1 | 125.0 |

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 04 сарын эцэст

| Сумын нэр | Амаржсан эх | Эхийн эндэгдэл | Амьд төрсөн хүүхэд | 1 | 1-5 |
|---------------|-------------|----------------|--------------------|-------------------------------|----------------------------|
| | | | | хүртэл насандаа эндсэн хүүхэд | хүртэл насны эндсэн хүүхэд |
| Тоо | | | | | |
| Дүн | 464 | 0 | 464 | 5 | 1 |
| Айраг | | | | | |
| Алтанширээ | | | | | |
| Даланжаргалан | | | | | |
| Дэлгэрэх | | | | | |
| Иххэт | 1 | | 1 | | |
| Мандах | | | | | |
| Өргөн | | | | | |
| Сайхандулаан | | | | | |
| Улаанбадрах | | | | 1 | |
| Хатанбулаг | 1 | | 1 | | |
| Хөвсгөл | 0 | | | | |
| Эрдэнэ | 1 | | 1 | | |
| Сайншанд | 382 | | 381 | 2 | |
| Замын - Үүд | 79 | | 80 | 2 | 1 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 04 сарын эцэст

| Үзүүлэлт | 2017 I-IV | 2017 I-IV | Өсөлт | |
|-----------------------------|-----------|-----------|-------|-------|
| | тоо | | | хувь |
| Халдварт өвчний гаралт-Бүгд | 396 | 215 | -181 | 54.3 |
| Вируст гепатит | 6 | 1 | -5 | 16.7 |
| Сүрьеэ | 34 | 33 | -1 | 97.1 |
| Тэмбүү | 39 | 37 | -2 | 94.9 |
| Заг хүйтэн | 53 | 69 | 16 | 130.2 |
| Трихоминиаз | 43 | 28 | -15 | 65.1 |
| Цусан суулга | 6 | 10 | 4 | 166.7 |
| Бусад | 215 | 37 | -178 | 17.2 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга
ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 04 сарын эцэст

| Боловсролын түвшингээр | 2015 IV | 2016 IV | 2017 IV | 2018. IV | $\frac{2018. IV}{2015. IV}$ | $\frac{2018. IV}{2017. IV}$ |
|------------------------|-----------|---------|---------|----------|-----------------------------|-----------------------------|
| | хүний тоо | | | | хувь | |
| ДҮН | 1 326 | 1 129 | 1 733 | 741 | 55.9 | 42.8 |
| Үүнээс: Эмэгтэй | 758 | 602 | 902 | 355 | 46.8 | 39.4 |
| Магистр, доктор | 3 | 10 | 7 | 1 | 33.3 | 14.3 |
| Дээд боловсролтой | 376 | 280 | 415 | 163 | 43.4 | 39.3 |
| Тусгай дунд | 167 | 136 | 178 | 35 | 21.0 | 19.7 |
| Техник мэргэжлийн | 109 | 130 | 163 | 50 | 45.9 | 30.7 |
| Бүрэн дунд | 438 | 385 | 732 | 440 | 100.5 | 60.1 |
| Бүрэн бус дунд | 183 | 148 | 194 | 31 | 16.9 | 16.0 |
| Бага | 44 | 32 | 35 | 4 | 9.1 | 11.4 |
| Боловсролгүй | 6 | 8 | 9 | 17 | 283.3 | 2.2 ² |

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 04 сарын эцэст

| | Ажилгүй иргэдийн тоо | | Ажилд орсон хүний тоо | | Шинээр бүртгүүлсэн хүний тоо | |
|---------------|----------------------|----------|-----------------------|----------|------------------------------|----------|
| | 2017. IV | 2018. IV | 2017. IV | 2018. IV | 2017. IV | 2018. IV |
| ДҮН | 1733 | 741 | 127 | 43 | 247 | 767 |
| Айраг | 200 | 21 | 23 | 0 | 24 | 44 |
| Алтанширээ | 22 | 6 | 3 | 5 | 9 | 29 |
| Даланжаргалан | 63 | 35 | 5 | 0 | 10 | 27 |
| Дэлгэрэх | 47 | 20 | 12 | 2 | 22 | 7 |
| Иххэт | 41 | 40 | 0 | 2 | 0 | 38 |
| Мандах | 86 | 12 | 2 | 9 | 0 | 25 |
| Өргөн | 85 | 20 | 4 | 0 | 35 | 19 |
| Сайхандулаан | 51 | 7 | 4 | 0 | 11 | 9 |
| Улаанбадрах | 32 | 12 | 2 | 6 | 1 | 21 |
| Хатанбулаг | 49 | 17 | 4 | 0 | 6 | 28 |
| Хөвсгөл | 32 | 7 | 12 | 4 | 13 | 14 |
| Эрдэнэ | 30 | 7 | 3 | 1 | 13 | 15 |
| Сайншанд | 725 | 413 | 23 | 11 | 74 | 355 |
| Замын - Үүд | 270 | 124 | 30 | 3 | 29 | 136 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 04 сарын эцэст

| Салбарын ангилал | 2017.IV | 2018.IV |
|---|---------|---------|
| | Тоо | |
| Бүгд | 227 | 59 |
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт | 9 | 2 |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр | 91 | 13 |
| Боловсруулах үйлдвэрлэл | | |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | | 1 |
| Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | | |
| Барилга | 1 | |
| Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ | | |
| Тээвэр агуулахын үйл ажиллагаа | | 7 |
| Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | | |
| Мэдээлэл, холбоо | 1 | |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 1 | |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | | |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | | |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | | 1 |
| Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 34 | 9 |
| Боловсрол | 18 | 7 |
| Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ | 12 | 2 |
| Урлаг, үзвэр,тоглоом наадам | 7 | |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 53 | 17 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ | | |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | | |

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 04 сарын эцэст

| Үзүүлэлт | 2017. IV | 2018. IV |
|---|----------|----------|
| | Тоо | |
| Бүгд | 227 | 59 |
| Менежер | 9 | |
| Мэргэжилтэн | 72 | 13 |
| Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн | 22 | 9 |
| Контор, үйлчилгээний ажилтан | 10 | 3 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 35 | 9 |
| ХАА, ой загас агнуурын ажилтан | | 2 |
| Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан | 20 | 2 |
| Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, үгсрагч | 28 | 8 |
| Энгийн ажил мэргэжил | 28 | 10 |
| Зэвсэгт хүчний ажил мэргэжил | 3 | 3 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 04 сарын эцэст

| Үзүүлэлт | 2017. IV | | 2018. IV | |
|---|----------|---------|----------|---------|
| | Бүгд | эмэгтэй | Бүгд | эмэгтэй |
| | Тоо | | Тоо | |
| Бүгд | 127 | 70 | 43 | 26 |
| Менежер | 7 | 2 | | |
| Мэргэжилтэн | 25 | 20 | 9 | 7 |
| Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн | 10 | 9 | 5 | 5 |
| Контор, үйлчилгээний ажилтан | 6 | 5 | 3 | 3 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 24 | 16 | 8 | 5 |
| ХАА, ой загас агнуурын ажилтан | | | | |
| Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан | 7 | 2 | 2 | 1 |
| Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч | 25 | 5 | 2 | 1 |
| Энгийн ажил мэргэжил | 22 | 10 | 11 | 2 |
| Зэвсэгт хүчний ажил мэргэжил | 1 | 1 | 3 | 2 |

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 04 сарын эцэст

| Салбарын ангилал | Бүгд | Эмэгтэй | Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар | |
|--|------|---------|--------------------------------------|--------|
| | | | Байнга | Улирал |
| | Тоо | | | |
| Бүгд | 19 | 8 | 17 | 2 |
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 1 | | 1 | |
| Уул уурхай олборлолт | | | | |
| Боловсруулах үйлдвэрлэл | | | | |
| Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж | | | | |
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент | | | | |
| Барилга | 11 | 4 | 11 | |
| Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ | 1 | 1 | 1 | |
| Тээвэр агуулахын үйл ажиллагаа | | | | |
| Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | | | | |
| Мэдээлэл холбоо | | | | |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | | | | |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | | | | |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | | | | |
| Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | | | | |
| Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал | 3 | | 3 | |
| Боловсрол | 1 | 1 | | 1 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 2 | 2 | 1 | 1 |
| Урлаг үзвэр тоглоом наадам | | | | |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | | | | |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй | | | | |
| Олон улсын байгууллагын үйл ажиллагаа | | | | |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

| Үзүүлэлт | Олгосон тэтгэвэр тэтгэмж | | 2018 I-IV |
|--------------------------------------|-----------------------------|-----------|-----------|
| | 2017 I-IV | 2018 I-IV | 2017 I-IV |
| | сая төгрөг | | хувь |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 8 623.4 | 10 504.7 | 121.8 |
| Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн | 5 256.0 | 6 606.2 | 125.7 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 598.9 | 747.4 | 124.8 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1 664.9 | 1 760.8 | 105.8 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангийн | 865.8 | 1 089.8 | 125.9 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 237.8 | 300.5 | 126.4 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | 12353.7 | 14282.2 | 115.6 |
| Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн | 9 034.3 | 10 432.6 | 115.5 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 649.8 | 782.0 | 120.3 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1 828.2 | 2 176.1 | 119.0 |
| ҮОМШӨ**-ний даатгалын сангийн | 504.6 | 651.6 | 129.1 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 336.8 | 239.9 | 71.2 |

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

| Үзүүлэлт | ХЭМЖИХ НЭГЖ | 2017 I-IV | 2018 I-IV | 2018 I-IV 2017 I-IV |
|---------------------------------------|----------------|-----------|-----------|------------------------|
| 1. Заавал даатгуулагч хүний тоо | тоо | 13687 | 14586 | 106.6 |
| Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага | тоо | 6374 | 7296 | 114.5 |
| Төсөвт байгууллага | тоо | 7313 | 7290 | 99.7 |
| 2. Олгосон тэтгэвэр | сая төгрөг | 9300.1 | 10716.8 | 115.2 |
| Үүнээс: Өндөр насны тэтгэвэр | сая төгрөг | 6836.2 | 7794.8 | 114.0 |
| Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр | сая төгрөг | 985.3 | 1211.5 | 123.0 |
| Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | сая төгрөг | 469.3 | 533.3 | 113.6 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр | сая төгрөг | 280.9 | 289.1 | 102.9 |
| Цэргийн тэтгэвэр | сая төгрөг | 728.4 | 888.1 | 121.9 |

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

| Үзүүлэлт | Хамрагдсан хүний тоо | | 2018 I-IV | Олгосон тэтгэвэр тэтгэмж | | 2018 I-IV |
|---|----------------------|--------------|------------------|--------------------------|------------------|------------------------|
| | 2017 I-IV | 2018 I-IV | 2017 I-IV | 2017 I-IV | 2018 I-IV | 2017 I-IV |
| | тоо | тоо | хувь | мянган төгрөг | | хувь |
| НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ | 15232 | 19458 | 127.7 | 2030616.8 | 2828849.3 | 139.3 |
| 1. Халамжийн тэтгэвэр | 1154 | 1274 | 110.4 | 309222.3 | 735559.9 | 2.3² |
| Ахмад настны тэтгэвэр | 51 | 54 | 105.9 | 11979.7 | 29516.2 | 2.4 ² |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр | 1103 | 1220 | 110.6 | 297242.6 | 706043.7 | 2.3 ² |
| 2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж | 1037 | 990 | 95.5 | 228101.1 | 248214.4 | 108.8 |
| Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж | 961 | 930 | 96.8 | 211936.8 | 232213.9 | 109.6 |
| Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж | 51 | 48 | 94.1 | 11786.7 | 13453.6 | 114.1 |
| Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж | 5 | 6 | 120.0 | 913.1 | 1434.0 | 157.0 |
| Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн | 11 | 5 | 45.5 | 2318.9 | 1048.9 | 45.2 |
| Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 9 | 1 | 11.1 | 1145.6 | 64.0 | 5.6 |
| 3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн | 923 | 863 | 93.5 | 330190.0 | 188536.5 | 57.1 |
| 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж | 300 | 219 | 73.0 | 193928.4 | 123516.5 | 63.7 |
| Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн | 582 | 624 | 107.2 | 127061.6 | 41460.0 | 32.6 |
| Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ | 37 | 4 | 10.8 | 3600.0 | 360.0 | 10.0 |
| 2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж | 1 | 5 | 5.0 ² | 2000.0 | 10000.0 | 5.0 ² |
| 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн | 2 | 3 | 150.0 | 2400.0 | 3600.0 | 150.0 |
| Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх | 1 | 5 | 5.0 ² | 1200.0 | 6000.0 | 5.0 ² |
| Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн | | 3 | 0.0 | | 3600.0 | |
| 4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал | | | | | | |
| 5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал | 5445 | 5971 | 109.7 | 360226.7 | 233397.4 | 64.8 |
| Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт | 3530 | 3381 | 95.8 | 133710.8 | 60307.7 | 45.1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт | 125 | 136 | 108.8 | 23193.2 | 17641.0 | 76.1 |
| Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил | | | | | 2693.1 | |
| Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | | 1596 | 0.0 | | 74032.0 | |
| Банкны шимтгэл | | | | | 1286.5 | |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт | 1790 | 858 | 47.9 | 203322.7 | 77437.1 | 38.1 |
| 6. Бусад хамалжийн дүн | 6673 | 10360 | 155.3 | 802876.7 | 1423141.1 | 177.3 |
| Алдарт эхийн одонгийн тусламж | 4526 | 4620 | 102.1 | 613880.0 | 620760.0 | 101.1 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 15 | 18 | 120.0 | 9636.7 | 11200.0 | 116.2 |
| Цалинтай ээж хөтөлбөр | | 3320 | 0.0 | | 568458.8 | 0.0 |
| Насны хишгийн зардал | 2132 | 2265 | 106.2 | 179360.0 | 189730.0 | 105.8 |
| Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал | | 137 | 0.0 | | 32992.3 | 0.0 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ

4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

| Хэргийн төрөл | 2017 I-IV | 2018 I-IV | зөрүү | Хэргийн бүтэц | |
|--|-----------|-----------|-------|---------------|-------|
| | | | | 2017 | 2018 |
| | тоо | хувь | | | |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН | 223 | 203 | -20 | 100.0 | 100.0 |
| Хүн амины гэмт хэрэг | 15 | 6 | -9 | 6.7 | 3.0 |
| Дээрмийн гэмт хэрэг | 1 | 2 | 1 | 0.4 | 1.0 |
| Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг | 3 | 5 | 2 | 1.3 | 2.5 |
| Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг | 61 | 41 | -20 | 27.4 | 20.2 |
| Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 73 | 97 | 24 | 32.7 | 47.8 |
| Хулгайлах | 44 | 48 | 4 | 19.7 | 23.6 |
| Залилах | 3 | 16 | 13 | 1.3 | 7.9 |
| Гээгдэл эд зүйл ашиглах | | 4 | 4 | 0.0 | 2.0 |
| Хөрөнгө завших | 3 | 7 | 4 | 1.3 | 3.4 |
| Эд хөрөнгө устгах, гэмтээх | | 1 | 1 | 0.0 | 0.5 |
| Мал хулгайлах | 23 | 21 | -2 | 10.3 | 10.3 |
| Улсын хийлээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн | 8 | 14 | 6 | 3.6 | 6.9 |
| Авилгын гэмт хэрэг | 2 | | -2 | 0.9 | 0.0 |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг | | 6 | 6 | 0.0 | 3.0 |
| Нийтийн албан ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг | | 4 | 4 | 0.0 | 2.0 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг | | 5 | 5 | 0.0 | 2.5 |
| Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 23 | 15 | -8 | 10.3 | 7.4 |
| Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг | 1 | | -1 | 0.4 | 0.0 |
| Бусад гэмт хэрэг | 36 | 8 | -28 | 16.1 | 3.9 |
| Хүнд гэмт хэрэг | | 52 | 52 | 0.0 | 25.6 |
| Хөнгөн гэмт хэрэг | | 151 | 151 | 0.0 | 74.4 |
| согтуугаар үйлдсэн | 75 | 21 | -54 | 33.6 | 10.3 |
| гудамж, олон нийтийн газарт | 28 | 26 | -2 | 12.6 | 12.8 |
| Гэмт хэргийн гэр орон сууцанд | 69 | 52 | -17 | 30.9 | 25.6 |
| тоо бүлэглэн үйлдсэн | 24 | 12 | -12 | 10.8 | 5.9 |
| хүүхэд оролцсон | 2 | 1 | -1 | 0.9 | 0.5 |
| эмэгтэй хүн оролцсон | 33 | 18 | -15 | 14.8 | 8.9 |
| 06.00 -14.00 | 58 | 61 | 3 | 26.0 | 30.0 |
| Гэмт хэрэг 14.00 -19.00 | 64 | 44 | -20 | 28.7 | 21.7 |
| үйлдсэн цаг 19.00 - 22.00 | 35 | 26 | -9 | 15.7 | 12.8 |
| 22.00 - 06.00 | 66 | 72 | 6 | 29.6 | 35.5 |
| Гэмт хэргийн нас барсан хүний тоо | 11 | 8 | -3 | 4.9 | 3.9 |
| улмаас гэмтэж бэртсэн хүний тоо | 78 | 40 | -38 | 35.0 | 19.7 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар



4.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО , сумаар

| | 2017 I-IV | 2018 I-IV | Үүнээс: хэргийн төрлөөр | | | | | | Бусад |
